



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

2024 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын үндсэн эд хөрөнгө, материалын 2024 оны хагас жилийн тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
- Гишүүд: Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
- Маркетинг, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
- Дотоодын аялал хариуцсан мэргэжилтэн
- Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
- Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

2.Тооллогын комиссын гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

